



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/252

Хэрлэн сум

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны
үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2023 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Бор-Өндөр сумын хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаанд хяналт хийх, зөвлөн туслах арга хэмжээнд шаардагдах зардалд 1,560,480 (нэг сая таван зуун жаран мянга дөрвөн зуун наян) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2.Энэхүү зардлыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Хүүхэд ээлтэй орон нутаг болно зардал”-аас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, зөвшөөрсүгэй.

3.Хяналт шалгалтын үйл ажиллагааг заасан хугацаанд зохион байгуулж, удирдлагын зөвлөлд тайлагнахыг Засаг даргын орлогч, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны дарга (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ